

МОНГОЛ ХЭЛНИЙ ТӨЛӨӨЛӨН НЭРЛЭХ ЁСНЫ ӨВӨРМӨЦ ОНЦЛОГ

Д. Бадамдорж *

Монгол хэлний үгийн сангийн олон утгат үг (polysemy) үүсгэх аргын нэг нь төлөөлөн нэрлэх ёс (synecdoche) юм. Төлөөлөн нэрлэх ёс бол бүхэл зүйлийг хэсгээр нь нэрлэх, эс бөгөөс бүхлээр нь хэсгийг нэрлэх хүний хэл, сэтгэхүйн холбооны маш чухал үйл ажиллагааны илрэл мөн билээ. Бид чухам юуг юугаар төлөөлөн нэрлэж байгаагаар нь шалгуур хийж, эл ёсыг ангилж, монгол хэл, сэтгэхүйн үүднээс түүний өвөрмөц онцлогийг ажиглаж, тус өгүүллийг бичлээ.

Академич Ш. Лувсанвандан “Манай хэл болбоос манай сэтгэлгээ лүгээ маш нягт холбоотой бөгөөд хэл ба түүний хуулийг судлах явдал болбоос өөрсдийн сэтгэлгээний лаборторит орсон лугаа адил буюу” (4:01-02) хэмээн хэлсэн ёсоор бид монгол хүн бодот байдлыг сэтгэж танин мэдсэний тод илэрхийлэл болсон, үгийн сангийн төлөөлөн нэрлэх ёсны уг чанарыг судалснаа Та бүхэнд толилуулъя.

Бидний судалгааны судлагдахуун бол шим ба сав ертөнцийн (амьтай, амьгүй) бүхэл юмсыг түүний хэсгээр нь, хэсгийг бүхлээр нь төлөөлөн нэрийдсэн монгол хэл, сэтгэхүйн холбооны өвөрмөц онцлог тал болно. Өөрөөр хэлбэл, бүхлийг хэсгээр нь, хэсгийг бүхлээр нь нэрийдэхдээ бодот байдлыг оюун ухаандаа хэрхэн тусган мэдээд, түүнийгээ хэлний тэмдгээр яаж илэрхийлж байгаа нь судалгааны сонирхол ихэд татаж байна. Эл монгол сэтгэхүй, хэлний үйл ажиллагааг илтгэсэн монгол хэлний төлөөлөн нэрлэж байгаа арга ухааныг дараахи байдлаар ангилав. Үүнд:

1. Хүнийг эрхтэний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй,
2. Амьтныг эрхтэний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй,
3. Ургамлыг эрхтэний нэрээр нь болон амьтны эрхтэний нэрээр төлөөлөн нэрлэхүй,
4. Юмсыг хэсгийн нэрээр нь төлөөлөн нэрлэхүй гэх мэт. Эдгээр төлөөлөн нэрлэх арга ухааныг авч үзье.

НЭГ. Хүнийг эрхтэний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй.

Монгол хүний чухал цөөн хэдэн эрхтэний нэрээр монгол хүнийг төлөөлөн нэрлэх бөгөөд монгол хэлний үгийн сангийн нэгж болсон хүн, толгой, ам, гар, хөл гэх мэт үглэвэр (lekseme)-ийг олон утгатай болгодог байна. Тухайлбал,

* МУИС, Монгол хэл, соёлын сургууль, Хэл шинжлэлийн тэнхим

ХҮН (хүний хамрын баганын ёроол хүртэлх дээд уруулд орших ховилын нэр). Эл үгээр хэл, сэтгэхүй эзэмнэгч бодгалийг төлөөлөн нэрлэжээ. Жишээ нь: Хүн, хүн төрөлхтөн, хүн амьтан, хүн хар, хүний мөс, хүний сайхан сэтгэл гэх мэт.

ТОЛГОЙ (хүний биеийн дээд хэсгийн гол эрхтэний нэр). Эл нэрээр зүдэг хүнийг төлөөлөн нэрлэдэг. Жишээ нь: “Чихгүй толгой, Цээжгүй бөгс” (дуулгаваргүй хүн 7 :350), “Учиртай гурван толгой” (Д. Нацагдорж), “Дүйрсэн хэрэг, Дүмбийсэн толгой”, хөгшин толгой (“Хуучин хүний яриаг ихэд сонсч, хэдэн арван жил нилээд юмыг өнгөрүүлсэн тул ХӨГШИН ТОЛГОЙ сүрхий хаширжжээ.” (8:240), хөлдүү толгой, дүлий толгой, усан толгой гэх мэт. Эдгээр хэлц ба хэллэгт байгаа ТОЛГОЙ хэмээх үглэвэр хүн гэх утгатай байна.

АМ (хүн амьтны хоёр уруулын завсархи сүвийн нэр). Эл нэрээр ихэвчилэн ядуу зүдүү, бүтэлгүй хүнийг төлөөлөн нэрлэдэг. Жишээ нь: “...Дөрвөн өлөн ам дагуулсан...” (Б. Ринчен, 9 :16), “Бэлэн ам, Шалдан гуя” (хэлц) гэх мэт.

Хүн ам гэж хоршин хэлж, олон хүнийг заана. Монгол улс 2013 оны байдлаар 2 сая 800 гаруй мянган хүн амтай, хүн амын тооллого гэх мэт.

ГАР (хүний мөрнөөс гарын хурууны үзүүр хүртэлх эрхтэний нэр). Эл нэрээр сайн муу шинж нь илэрсэн хүнийг төлөөлөн нэрлэдэг. Жишээ нь: Баруун гар(сайн нөхөр), их гар (бүтэлгүй хүн, дээрэмчин), хүнд гар (дэггүй хүн), урт гартай (хулгайч), гар хөл болох (хань хамсаатан нь болох) гэх мэт.

ХӨЛ (хүний ташаан толгойноос доош хөлийн хурууны үзүүр хүртэлхи эрхтэний нэр). Эл нэрээр нэлээд олон хүнийг төлөөлөн нэрлэдэг. Жишээ нь: Хөлтэй, хөл ихтэй (хүн олон байгаа), хөл бага, хөлд дарагдах, их хөлийн газар (хүн их цугласан газар) гэх мэт.

Хүний зарим эрхтэний нэр оролцсон хэллэг, өвөрмөц хэлц нь тухайн хүний шинжийг танин мэдсэний үр дүнгээр хэрэглээний явц дунд хүнийг төлөөлөн нэрлэсэн утгатай болдог байна. Жишээ нь: Амьд хэл (олзлогдсон хүн), аавын цээж (аавархуу залуу), өрөөсөн бөөр (зан ааш, тааруу үйлээрээ нөгөө хүнтэй адил хүн), халуун элэгтэн (сайн санаат хүмүүс), хар элэгтэн (нэг удам угсааны бус хүмүүс), хар тэргүүт (хүн төрөлхтөн), цагаан арьстан (арьсны өнгө цагаан хүмүүс), хар арьстан (арьсны өнгө хар хүмүүс), шар арьстан (арьсны өнгө шар хүмүүс) гэх мэт. Энд хэл, цээж, бөөр, элэг, тэргүүн, арьс хэмээх үглэврүүд хүнийг төлөөлөн заасан утгалбар (sememe) -тай болсон гэсэн үг юм.

Монгол хэлний өвөрмөц хэлцийн дотор хүний эрхтэний нэр (хэсгийн нэр)-ийн оролцоотойгоор хүний шинжийг төлөөлөн утга шилжүүлэн нэрлэсэн, өвөрмөц нэрийдэл бий. Жишээ нь: Эрүү өвдөг нийлэх (өтлөх), эрүү толгой зодолдуудах (идэх), яс арьс болох (турах), царай алдах (ядрах), хэл ам удах (яршиглах), шүд зуух (тэвчих), шөрмөс заах (гөжих), шийр хатаах (дууриах), шазуур зуух (занах), яс махны тасархай (ах дүү), элэг буруу (хүнийрхүү), элэг бүтэн (цөм энх тунх), чулуун зүрх (хатуу сэтгэл), чих хатуу (дүлий, дуулгаваргүй), чих зөөлөн (дуулгавартай), нүд нь унах (горьдох), хөл хүнд (жирэмсэн) гэх мэт.

Бас монгол үндэстэн, ястныг содон эд өлгийн зүйлээр нь төлөөлөн нэрлэх нэгэн өвөрмөц онцлог буй болжээ. Жишээлэхэд, Эсгий туургатан, монгол туургатан, монгол тулгатан, шар малгайтан, нэгэн өрх гэх мэт. Энд “туурга, тулга, малгай, өрх” гэсэн эд өлгийг нэрийдсэн дөрвөн үглэвэр хүмүүсийг илэрхийлсэн утгатай болсон.

Хүний хоч нэр бол тухайн хүнийг хэсгийн нэр буюу эрхтэний нэрээр нь төлөөлөн нэрлэсэн байдаг. Жишээ нь: Эрүү Цэдэн буюу ЭРҮҮ, сахал Очир буюу САХАЛ, дэлдэн Сүрэн буюу ДЭЛДЭН, Алаг нүдэн Туяа буюу АЛАГ НҮДЭН гэх мэт.

ХОЁР. Амьтныг эрхтэний нэрээр нь төлөөлөн нэрлэхүй

Монгол хүн гэрийн тэжээмэл хийгээд зэрлэг амьтдыг ихэвчилэн гадаад шинжээр нь сэтгэж танин мэдэж, түүний содон эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн байдаг юм. Тодруулбал, аймаг, нам амьтанд байгаа нэгэн өвөрмөц эрхтэнээр нь тэрхүү аймаг, нам, зүйл амьтныг нэрлэсэн нэр томъёог өргөн хэрэглэж байна. Монгол хэлний хэвшмэл хэлцийн дотор “Идсэн ЭРҮҮ хувхайрдаг, Идүүлсэн бут ургадаг.” хэмээн бүх амьтныг “эрүү” гэх эрхтэнээр нь төлөөлөн нэрлэсэн байдаг билээ. Монгол хэлний үг бүтээх -тан, -тэн, -тон, -төн дагавар маш өндөр давтамжтай болох нь бидний цуглуулсан жишээ баримтаас илэрхий байна. Жишээ нь: Араатан, жигүүртэн, хөхтөн, туурайтан, тууртан, туруутан, соёотон, хөлтөн, сээртэн, далавчтан, нялцгай биетэн, өргөст арьстан, хошуутан, ууттан, битүү туурайтан, салаа туурайтан, амьтан гэх мэт. Амьтныг эрхтэнээр нь төлөөлөн нэрлэсэн, тэрхүү монгол сэтгэхүй, хэлний холбооны онцлогийг өөрийн судалгааг үндэслэж танилцуулъя.

Монгол хүн таван хошуу малыг маш эртнээс нааш адуулж ирэхдээ бог бод малын бие эрхтэний өвөрмөц содон шинжүүдийг танин мэдээд, бүхлийг хэсгээр нэрлэх буюу төлөөлөн нэрлэх ёсыг буй болгосон байна. Үүнд:

-Малыг “толгой, хошуу” гэх зэрэг эрхтэнээр нь ерөнхийлөн төлөөлөн нэрлэдэг. Жишээ нь: Манай улс дөч гаруй сая ТОЛГОЙ малтай. Тал дүүрэн бэлчих таван ХОШУУ мал. гэх мэт. Энэ нь малын толгой, хошуу гэсэн содон эрхтэний нэрээр нэршиж заншсан сэтгэхүй, хэлний өвөрмөц холбоо юм.

-Гэрийн тэжээмэл амьтдыг тодорхой шинж буюу зүсмээр нь төлөөлөн нэрийдэх ухаан нүүдэлчдийн танин мэдэхүй ба харааны ойн онцлог юм. Тухайлбал, эм малын зүсмийг хүйсийн хамтаар ЦАГААГЧ (эм малын цагаан зүсэм), ХАРАГЧ, БОРОГЧ, УЛААГЧ, ХӨХӨГЧ, ХУЛАГЧ, ШАРАГЧ гэхчилэн нэрийднэ. Мөн малыг зөвхөн зүсмээр нь нэрлэж, нэгийг нөгөөгөөс ялгах арга ухаан уламжлан боловсорсон байна. Үүнд:

-Хонийг хар толгойт, бор толгойт, халзан цагаан, цанхир, борлог, харлаг, шар халзан, хөх халзан, бор, хар гэх мэт.

-Ямааг цагаан, хар, хөх, улаан, саарал гэх мэт.

-Адууг бор, борлог, бүгээн, цагаан, хар, харлаг, хээр, халтар, шарга, хул, зээрд, хүрэн, буурал, саарал, халиун, цавдир, цоохор, алаг гэх мэт.

-Үхрийг талын улаан, цагаан, ягаан, хар, хүрэн, хөх, хар тарлан, бор тарлан гэх мэт.

-Тэмээг цагаан, хар, хүрэн, шар гэх мэт.

-Аливаа амьтны шүд бол амьтныг таних нэрлэх гол эрхтэн юм. Тийм учраас нүүдэлчин ард түмэн малыг шүдээр нь төлөөлөн нэрлэж иржээ. Адуу, үхэр, тэмээг гурван настайгаас нь, хонь, ямааг хоёр настайгаас нь ШҮДЛЭН гэж нэрлэж, шүд нь жигдрэн ургаж байгааг таньжээ. Энэчилэн ХЯЗААЛАН, СОЁОЛОН хэмээх нэрийдэл бол малыг шүдээр нь нэрлэсэн хэрэг юм.

Монгол мал тус бүрийг эрхтэнээр нь төлөөлөн нэрлэх байдал харилцан адилгүй тус тус онцлогтой байна. Тухайлбал,

-Хонийг түүний эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн нь: ӨӨХӨН СҮҮЛТ (Сартуул, Дархад, Барга, Сутай омгийн хонь), УУЦАН СҮҮЛТ(Торгууд, Алтанбулаг үржлийн

хэсгийн хонь) (5:17), ХАР ХӨЛ (буржгар бөгөөд тачир үстэй хонь, каракуль), ШИЙР МАЛ (хонь ямааг Ойрадууд ийнхүү нэрлэж байна (1:169), УГАЛЗ (зэрлэг хонины эр нь, хонины эврийн байдлаар нэрлэсэн) гэх мэт.

-Ямааг түүний эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн нь: ТУЛМАН ХӨХТ (Говь-Алтай аймгийн Эрдэнэ, Бигэр, Дарви, Халиун сумд өсгөж ирсэн. Хөхний урт 5,5 см, хөхний бүслүүрийн хэмжээ 5-7 см учир ийнхүү нэрлэжээ. (2:70), АЦ ТУРУУТАН (туурай нь хоёр хэсэгтэй учир ийнхүү нэрлэсэн), ШООРОН ЭВЭРТ (эвэр нь дээш гозойсон ямаа), СЭЛМЭН ЭВЭРТ (эвэр нь эгц бөгөөд хавтгай урт ямаа) гэх мэт.

-Адууг түүний эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн нь: ХУР ДЭЛТ (дэлийг нь ер хяргаагүй азарга), ҮҮР СҮҮЛТ (сүүл нь ширэлдсэн адуу), ЦОМБОН ТУУРАЙТ (туурайны байдлаар нэрлэсэн), БИТҮҮ ТУУРАЙТАН (адугуу туурайгаар нь төлөөлсөн нэр) гэх мэт.

-Үхрийг түүний эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн нь: АЦ ТУРУУТАН (дэлэнтэн анги, туруутан баг, тугалмайтан овгийн, үхэр төрөл, адгуус), ДАЛИУ ЭВЭРТ (эвэр нь доош налж ургасан үхэр), ЦАГААН ТОЛГОЙТ (Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Дорнод аймагт үржүүлж байсан. Шилмэл үнээ 780 кг, бух 1100 кг байдаг (2:112), үхрийг хараахдаа АДСАГА гэх мэтээр нэрлэдэг.

-Тэмээг түүний эрхтэнээр төлөөлөн нэрлэсэн нь: Монголчууд тэмээг их төлөв бөхөөр нь төлөөлөн нэрийднэ. ТУГ ШИРЭЭ (хоёр бөх нь босоо тэмээ), СОЁО (урд бөх босоо, хойд бөх хэвтээ тэмээ), СОЛБИО (нэг бөх зөв тийш хэвтээ, нөгөө бөх буруу тийш хэвтээ тэмээ), АЯС (урд бөх хэвтээ, хойд бөх босоо тэмээ), ХАНАН (хоёр бөх нь зөв тийш, эсвэл буруу тийш ижилхэн хэвтээ тэмээ) гэх мэт. ШАР ШИЛБЭ (хоёр ба хоёр хагас настай тэмээ), тэмээг хараахдаа ҮДЭЭР гэх зэргээр нэрлэнэ.

Монголчууд зэрлэг амьтдыг эрхтэнээр нь тухайн амьтны содон сонин байдлыг ажиглаж, төлөөлөн нэрлэсэн байдаг. Жишээ нь: ЧИХТЭЙ (хул, шарга зүсмийн зэрлэг адууг чихээр нь нэрийдсэн нэр. Хулан.), Шар МААХАЙ (нас бие жагссан эр баавгайн нэр), Шар ЭВЭР (гурван настай зэрлэг хонийг эврээр нь нэрлэсэн нэр. Гурван настай угалз.), ХУЛГАР ШАР (тарвагыг чих болон зүсмээр нь нэрлэсэн нэр), МАЙГА БОР (баавгайг хөл болон зүсмээр нь өхөөрдөж нэрийдсэн нэр) гэх мэт. Чоныг АЛД АМТ (Баянхонгор), ИХ АМТ (Ховд, Архангай), САРЬСАН ХАМАРТ (Завхан), УРТ СҮҮЛТ (Дорнод), ЗӨӨЛӨН ХӨЛТ (Р. Жагварал 3:76) гэх мэтээр төлөөлөн нэрийдсэн байна.

Энэчилэн, шувуудыг их төлөв гадаад зарим эрхтэнээр нь төлөөлөн нэрлэдэг. Жишээлэхэд, ЖИГҮҮРТЭН (шувууд), ХАР НҮДЭН (начин шувууны адил махчин шувуу), ШАР ХӨМСӨГ (хятруу бялзуухайтай адил, хошуу жигүүр хар, хөл улаан, хөмсөг шар нэгэн зүйл бялзуухайн нэр), ЦАГААН ХӨМСӨГ (хөмсөг цагаан, хошуу харавтар, жигүүр эрэн, хөл нь шар, нэгэн зүйл бялзуухай) гэх мэт.

ГУРАВ. Ургамлыг бүхлийн хэсгийн нэрээр төлөөлөн нэрлэхүй

Ургамалд нэр өгөх монгол ухааныг байцаан үзвэл, ургамлыг бүтээх хэсгээр нь төлөөлөн нэрлэх, эсвэл амьтны эрхтэнээр зүйрлэж төлөөлөн нэрийдэх үндсэн хоёр арга байна. Тухайлбал,

-Ургамлыг эд эрхтэнээр нь нэрийдэх нь цөөвтөр боловч, НАВЧИТ мод, ШИЛМҮҮСТ мод, ЦЭЦЭГТ ургамал, БУУРЦАГТ ургамал, ИШИТ цэцэг гэх мэтээр нэрийднэ. Монгол хэлний “цэцэг” хэмээх үглэвэр бол:

1. Цэцэгт ургамлын бэлгээр үржих эрхтэний нэр, боролзгоны шар цэцэг, төмсний цагаан цэцэг гэх мэт.

2. Цэцэг бүхий ургамлын нэр. Цэцэг өргөх, цэцэг тарих, бэр цэцэг, цэцэг жимс гэх мэт. Иймд “цэцэг” гэх эрхтэний нэрээр бүхэл бүтэн ургамлыг нэрийдэж байгаа нь илэрхий байна.

-Ургамалд нэр өгөхдөө амьтны эрхтэнээр зүйрлэнгээ, бас төлөөлөн нэрлэсэн олон нэр бий. Шувууны таваг мэт хэлбэр бүхий навчтай, 20 см орчим өндөр, ишийн бүдүүн нь дэрсний хир, говирхог газар ургадаг, шарилжны төрлийн өвсийг ГАЛУУН ТАВАГ хэмээн нэрийдсэн байгаа явдал бол юуны өмнө ургамлын НАВЧИЙГ шувууны ТАВАГтай зүйрлэж, навчны шинж, тавагны шинж адил байгаа учраас эл ургамлыг навчаар нь нэрийдсэн мэт болж сэтгэгдэж байгаа юм. Ингэхээр төлөөлөн нэрлэх ёс (synecdoche)-ны үүднээс тайлбарлаж болох бүрэн боломжтой гэж болно. Зарим нэгэн жишээг дурдъя. Үүнд:

Амьтны эрхтэний нэр	ургамлын нэрс
ЧИХ:	хурган чих, дааган чих, согоон чих, гахайн чих.
ХОШУУ:	нохойн хошуу, хэрээн хошуу.
НҮД:	үхрийн нүд, хэрээний нүд, луугийн нүд, хонины нүдэн цэцэг.
ХЭЛ:	нохойн хэл, тэмээн хэл.
ТАВАГ:	заан таваг, булган таваг, галуун таваг, нугасан таваг.
ТАГНАЙ:	туулайн тагнай.
ШИЙР:	тарваган шийр, унанганы шийр, нохойн шийр.
ШИЛБЭ:	зээрэн шилбэ.
ХУМС:	матрын хумс.
ХӨХ:	гүүн хөх, тэмээн хөх.
ТУРУУ:	унаган туруу.
ЭЛЭГ:	чонын элэг.
ЗОГДОР:	бугын зогдор, зогдор өөвс.
ЗАСАА:	хурган засаа.
БӨӨР:	туулайн бөөр, хурганы бөөр.
ХӨЛ:	янгирын хөл, шувуун хөл.
ХАВИРГА:	тэмээн хавирга.
САХАЛ:	ямаан сахал.
УРУУЛ:	адууны уруул, морины уруул.
ТУУРАЙ:	бугын туурай, угалзан туурай.
СҮҮЛ:	гахайн сүүл, тэмээн сүүл, чонын сүүл, булган сүүл, үрээн сүүл, үнэгэн сүүл, зурман сүүл, оготнын сүүл, бухын сүүл, дааган сүүл гэх мэт.

ДӨРӨВ. Амьгүй юмыг түүний хэсгийн нэрээр нь төлөөлөн нэрлэхүй

Монгол хүний сэтгэн бодох үйл ажиллагаагаар бүхэл юмыг хэсгээр нь нэрийдсэн өвөрмөц нэрлэл бий болжээ. Тухайлбал,

ДУГУЙ (тэнхлэгт хүрдэн тулгуур, тэргэний дөрвөн дугуй), эл бүхлийн хэсгийг заасан үглэврээр хоёр дугуйтай, унадаг дугуй гэх бүхэл бүтэн нэгэн төрлийн техник хэрэгслийг төлөөлөн нэрийдэж байна. Дугуй унах, олон улсын дугуйн тэмцээн, дугуйн зам гэх мэт.

ҮЗЭГ (төмөр, ган зэргээр хийсэн бичих хэрэгслийн хошууны нэр, үзэгний хошуу, төмөр үзэг), эл бүхлийн хэсгийг заасан үглэврээр дотор нь бэх соруулж, энгэрт зүүж, үзэг бүхий бичих зурах хэрэгслийг төлөөлсөн нэр бүтээжээ. Үзэг нэгт нөхөд, алтан үзэг, үзэглэх гэх мэт.

ҮСЭГ (авиаг тэмдэглэх цагаан толгойн тэмдэг), эл бүхлийн хэсгийг заасан үглэврээр ГАРЫН ҮСЭГ хэмээх нийлмэл үг бүтээж, хүний таталган бичсэн нэр гэх утгатай бүхлийг төлөөлөн нэрийдсэн байна. Гарын үсэг зурах, үг үсгээс бүтнэ.

ӨЛМИЙ (1. Хөлийн тавхайн урд хэсэг, 2. Гутлын улны мөн урд хэсэг), эл бүхлийн хэсгийг заасан үглэврээр хүний газар гишгэж явах хос эрхтэнийг хүндэтгэн төлөөлөн нэрийджээ. Өлмий бат оршиг. Өлмийд нь багтах гэх мэт.

ХАНА (монгол гэрийн унь шал хоёрыг холбож, дугуйлан барих модон хэрэгслийн нэр), эл бүхлийн хэсгийг илтгэсэн үглэврээр монгол гэрийг төлөөлөн нэрлэсэн байна. Дөрвөн ханат, таван ханат, найман ханат, арван ханат гэх мэт.

Монгол хүн юмыг онцгой шинжээр нь төлөөлөн нэрлэх арга ухаантай билээ. Жишээ нь: ТООСТ гэх нь хорвоог, НАРТ гэх нь өртөнцийг, МОД ТОЛГОЙ гэх нь гаансыг, ГАЛЗУУ УЛААН гэх нь тамхийг тус тус төлөөлөн нэрлэсэн байгаа юм.

Бид монгол хэлний төлөөлөн нэрлэх ёсны өвөрмөц онцлогийг монгол хүний сэтгэн бодох байдлаар нь авч үзсэн тул дээрхи дөрвөн зүйлийн төлөөлөн нэрлэх арга байгааг тодорхойлов.

НОМ ЗҮЙ

1. Бадамдорж Д. “Монгол хэлний үгийн сангийн утгазүй” УБ. 2006. 169 дахь тал.
2. Дондог Ч. “Манай улсын малын үүлдрийн өнгөт зургийн альбом” УБ. 1976. 70, 112 дахь тал.
3. Жагварал Р. Монгол хэлний хүндэтгэлийн үг” УБ. 1976. 76 дахь тал.
4. Лувсанвандан Ш. “Монгол хэлний зүй” Цуглалт хаалга. 1951. 01-02 дахь тал.
5. Минжигдорж Б. “Буянт мал” УБ. 2001. 04-24 дэх тал.
6. “Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Таван боть” УБ. 2008.
7. “Mongolian proverbs” (A window into their world) Janice Raymond. UB. 2010. pp 350.
8. Нацагдорж Д. “Зохиолын түүвэр” УБ. 1955. 240 дахь тал.
9. Ринчен Б. “Үүрийн туяа” роман. УБ. 1970. 16 дахь тал.
10. Шагдарсүрэн О., Мөнхбаяр Х., Дүнчээ С. “Амьтан судлал” 6-7 –р анги. УБ. 1979. 3-262 дахь тал.

ABSTRACT

Synecdoche is a figure of speech in which a term for a part of something is used to refer to the whole of something. In my presentation I examine Mongolian ways of using synecdoche in relation to four kinds of subjects.

1. Referring to human beings by a term originally used for a part of the human body, such as hun(philtrum), am(mouth), gar(arm), xol(leg).

2. Referring to animals by the name of a part of their body, such as eruu(jaw). *(idsen eruu-animal).

3. Referring to plants by animal names, such as hurganii chih (lamb-ear), nohoin hoshuu(dog-snout).

4. Referring to whole things by names of their part, such as dugui(wheel), for bicycle, hana(wall) but dorwon hanat(four walled) means a four-walled yurt etc.